

ОНОШИЛГОО, ХЭМЖИЛ ЗҮЙН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020 оны 09 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 06-ны өдөр баталсан ИНҮТ-ийн харьяа Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 21/20 дугаар удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор П.Цогбаяр, Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, цалин хөлсний бүртгэл тооцоо зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

ИНЕГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан “Иргэний нисэхийн үндэсний төвийн журам”-ын 3.1.8-д ...ИНЕГ-ын даргаас шилжүүлсэн эрхийн хүрээнд ажилтны ажлын байрны тодорхойлолтыг баталж, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажилтнуудыг томилох, чөлөөлөх... гэж заасны дагуу ИНҮТ нь Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн ажилтнуудыг чөлөөлөх, томилох тушаал гаргаагүй байна.

ИНЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/286 дугаар тушаалаар баталсан “Оношилгоо хэмжил зүйн лабораторийн хэмжилт, шалгалт тохируулга болон сорил шинжилгээний ажлын үнэлгээ” нь тухайн үзүүлж байгаа үйлчилгээний өртөгөөс бага, үр ашгийн хувьд алдагдалтай болсон байна.

Тус лабораторийн ажилтнууд томилолтоор ажиллах хугацаанд нийтээр амрах амралтын өдрүүдэд болон баяр ёслолын өдрүүдэд ажилласан мөн ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй өдрүүдийг ажилтнуудын бичгээр гаргасан өргөдлийг үндэслэн чөлөөний хуудсаар нөхөн олгосон нь ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Нийтээр амрах долоо хоногийн амралтын өдрүүдэд ажилласан болон ээлжийн амралтаа биеэр нөхөн эдлэх зорилгоор ажилтнуудын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн ОХЗЛ-ийн эрхлэгч чөлөөний хуудсаар ажилтнуудад 2 болон түүнээс дээш хоногийн чөлөө олгосон нь ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг зөрчжээ.

Нийтээр амрах долоо хоногийн амралтын өдөр болон баяр ёслолын өдрүүдэд ажилласан ажилтнуудыг биеэр нөхөн амраахдаа ажил олгогч байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан шийдвэрлэхээр ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журамд заасан байтал ОХЗЛ-ийн эрхлэгч ажилтнуудын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу чөлөөний хуудсаар ажилтнуудад чөлөө олгох хэлбэрээр нөхөн амраасан байна.

Томилолтоор ажиллах хугацааг төлөвлөх, хянах, томилолтын удирдамжийг боловсруулах, батлах ажилтнууд төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар санаачилгатай ажиллаагүй байна.

Хэмжилт, шалгалт тохируулгын ажилд зарцуулах хөдөлмөрийн зарцуулалт буюу хүн/цаг-ийг мэдэхгүйгээс тухайн ажлыг гүйцэтгэх томилолтын хугацааг үндэслэлгүй тавих,

ажилтан нь нийтээр амрах амралтын өдрүүд болон баяр ёслолын өдрүүдэд томилолтоор ажиллаж, дараа нь нөхөн амрах үзэгдэл түгээмэл болсон байна.

ОХЗЛ-ийн үйл ажиллагаатай холбоотой гадны байгууллагуудтай байгуулсан гэрээний оршил хэсэгт ИНЕГ-ыг төлөөлөн нэг албан тушаалтны нэрийг бичсэн боловч гэрээний сүүлийн хуудсанд 2-4 албан тушаалтан гэрээ байгуулж гарын үсэг зурсан нь “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 2.4.5.2 заалтыг зөрчсөн байна. 2019 болон 2020 онд гадны байгууллагуудтай байгуулсан зарим гэрээ нь үг үсгийн алдаатай, гэрээний хугацааг гараар зассан нь Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 2.3.9 дэх заалтыг зөрчсөн байна.

2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хооронд ОХЗЛ-оос явуулсан албан бичигт ОХЗЛ-ын эрхлэгчийн гарын үсгийг чанарын менежер нь “эрхлэгч-г” гэж тэмдэглэн орлон зурсан байна.

ЖУ-14-ийн 2.4.7-д ...Дээж устгахдаа энэ журмын 2.3.2-т заасан хугацааг харгалзана... гэж заасан. Гэтэл 2.3.2-т ...Лабораторийн хуваарьт шилэн сав болон хэмжих хэрэгслүүдийг харилцагч байгууллагаас лабораторийн байранд хүлээн авна... гэж огт өөр зүйлийн тухай тусгасан. Мөн энэ заалтын төгсгөл хэсэгт “харилцагчид илгээсэн дээжийг 3 сар хадгална” гэсэн нь утга найруулгын хувьд алдаатай болсон байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаалын заалт нэг бүрийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллаагүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 7, тус нэгжид 5, нийт 12 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА